

МОНГОЛБАНКНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛӨӨС САНАЛ, ЗӨВЛӨМЖ ӨГӨВ

Монголбанкны Хяналтын зөвлөлийн 2011 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хурлаар Төв банк /Монголбанк /-ны тухай хуульд заасны дагуу Монголбанкны 2010 оны санхүүгийн тайланд Хяналтын зөвлөлөөс өгөх санал, зөвлөмжийн төслийг хэлэлцэн УИХ-ын холбогдох байнгын хороонд хүргүүлэхээр тогтов.

Хяналтын зөвлөлөөс Монголбанкны 2010 оны санхүүгийн тайланд дараах санал, зөвлөмжийг өгсөн байна.

1. Монголбанкны удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлангийн хөрөнгө эх үүсвэрийн дүн болон үйл ажиллагааны үр дүн нь аудитаар баталгаажуулсан дүнгээс дутуу тайлагнагдсан байдалд дүгнэлт хийж, банкны удирдлага тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад бүрэн нийцүүлж бэлтгэх;

2. 2010 оны санхүүгийн жилд Монголбанк 253 тэрбум 805 сая төгрөгийн алдагдалтай ажилласны голлох нь валютын ханшийн зөрүүнээс хамаарчээ. Энэ алдагдлаас шалтгаалан Монголбанкны балансад өөрийн хөрөнгийн дүн нь сөрөг утгатай гарсан байна. Иймд үнэт цаас гаргах замаар алдагдлаа нөхөх асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

3. Санхүүгийн тайлангаар гарсан үр дүнг тайлант оны төсөвтэй харьцуулан орлого, зарлагын зүйл тус бүрээр өсөлт, бууралтыг тодорхойлон, нөлөөлсөн хүчин зүйлийн шинжилгээ хийж, шинжилгээний үр дүнг шийдвэр гаргахдаа ашигладаг болох;

4. Аудитын дүгнэлтэд тодорхойлсон, Засгийн газрын төлөх 116 тэрбум төгрөгийн зээлийн төлөх хугацааны болон төлбөрийн хуваарийг холбогдох байгууллагатай зөвшилцөн баталгаажуулах ажлыг 2011 оны 3 дугаар улиралд багтаан шийдвэрлэх;

5. Аудит хийлгэх байгууллагыг сонгон шалгаруулах үйл явцыг шударга, холбогдох хуулийн шаардлагад нийцүүлэн зохион байгуулдаг болох асуудалд онцгой анхаарч ажиллахын зэрэгцээ аудитын байгууллагыг сонгон шалгаруулахдаа Хяналтын зөвлөлийн оролцоог хангаж ажиллах зэрэг санал, зөвлөмжийг өгсөн байна.

Мөн хурлаар Монголбанкны орон нутаг дахь салбарын ажил байдалтай танилцаж шалгасан дүнг хэлэлцээд:

- Монголбанкны орон нутгийн салбарын тоо, зохион байгуулалт, бүтэц, төсвийг тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкны салбар, нэгжийн тоо, тэдгээрийн байршил, дэд бүтцийн байдал, бэлэн мөнгөний урсгал, газар нутгийн хэмжээ зэрэгтэй уялдуулан тогтоох асуудлыг судалж хэрэгжүүлэх;

- Орон нутгийн салбарын удирдлагыг томилохдоо банкны салбарын ажлын зохих мэдлэг, дадлага туршлагатай боловсон хүчнийг сонгон Монголбанкны Зөвлөлөөр хэлэлцүүлж томилдог журамд шилжих;

- Монголбанкны хяналт шалгалтын болон бусад шаардлагатай чиглэлээр орон нутаг дахь салбарын ажилд мөрдлөг болгох дүрэм, журам, зааврыг шинэчлэн боловсруулж мөрдүүлж ажиллахыг Монголбанкны Ерөнхийлөгчид зөвлөмж болгосон байна.

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ